

ХҮН АМ, ӨРХИЙН БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР ХӨТЛӨХӨД АНХААРАХ АСУУДАЛ

Анхан шатны нэгжид дараах иргэдийг бүртгэхэд анхаарах шаардлагатай.

Үүнд: Үндсэн засаг, захиргааны нэгжээс өөр газарт сууж буй

1. Оюутан, сурагч;
2. Байр түрээсэлж буй хүмүүс;
3. Албан томилолтоор яваа хүмүүс: гэрээт цэргийн албан хаагч, геологи, хайгуулын ажилтнууд, гаалийн ажилчид, хөдөө орон нутагт гэрээгээр ажиллаж буй эмч, багш;
4. Ажилчдын дотуур байр;
5. Орон гэргүй иргэд;
6. Асрамжийн газрын асруулагчид, сэтгэцийн эмнэлэгт удаан хугацаагаар эмчлүүлэгчид;
7. МУ-д 6, түүнээс дээш сарын хугацаагаар суугаа гадаадын иргэд;

Эдгээр хүмүүсийг анхан шатны нэгжид бүртгэх маягтыг 2012 онд боловсруулахаар төлөвлөж байна. Харин 2011 оны жилийн эцсийн хүн ам, өрхийн бүртгэлийг явуулахдаа дээрх иргэдийг өрхөд хамаарахгүйгээр бүртгэж, мэдээллийг ХАӨБ-ийн программд шивж оруулна. ХАӨБ-ийн програмд шивэхдээ дараах иргэдийн хувьд өрхийн дугаарыг 9999 гээд ялгах кодын сүүлийн оронд 4 гэсэн код өгнө.

1. Оюутан, сурагч
2. Албан томилолтоор яваа хүмүүс: гэрээт цэргийн албан хаагч, геологи, хайгуулын ажилтнууд, гаалийн ажилчид, хөдөө орон нутагт гэрээгээр ажиллаж буй эмч, сувилагч
3. Ажилчдын дотуур байранд амьдарч буй хүмүүс
4. Орон гэргүй иргэд
5. Асрамжийн газрын асруулагчид, сэтгэцийн эмнэлэгт удаан хугацаагаар эмчлүүлэгчид

Дээрх хүмүүсийн мэдээллийг програмд шивэхдээ дараах үзүүлэлтээр оруулна.
Үүнд:

- Хаягийн хэсэг
- Өрхийн гишүүдийн бүртгэлийн хэсэг А1-А17-р асуулт

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГЫН ТОВЧОО